

2020 ОНЫ 03 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДРИЙН АЙМГИЙН  
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН АЖЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

№	7 хоногийн ажлын товч мэдээлэл
1	<p style="text-align: center;">03 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд аймгийн автотээврийн төвөөс 249 зорчигч зорчжээ</p> <p>Монгол улсын Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/19 тоот тушаал, Улсын Ерөнхий байцаагчийн 01/01 тоот албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах зорилгоор аймгийн Автотээврийн төвд 2020 оны 03 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 17:00 цагийн байдлаар Цэнгэл транс ХХК-ийн хот хооронд Өлгий-Улаанбаатар чиглэлд зорчсон 2 автобусны 104 зорчигч, Бүгд Найрамдах Казахстан улсын “АБИ АСТАНА” компанийн улс хооронд Өлгий-Нур-Султан-Караганда чиглэлд зорчсон 1 автобусны 48 зорчигч, Аман авто транс ХХК-ийн хот хооронд Өлгий-Улаанбаатар чиглэлд зорчсон 1 автобусны 49 зорчигч, Газрын Од ХХК-ийн хот хооронд Өлгий-Улаанбаатар чиглэлд зорчсон 1 автобусны 48 зорчигч нийт 5 автобусны 249 зорчигч нарт эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтэн биеийн халууныг хэмжиж үзлэг хийхэд халдварт өвчний сэжигтэй шинж тэмдэг илрээгүй болно.</p>
2	<p style="text-align: center;">24 ЦАГИЙН БЭЛЭН БАЙДАЛТАЙ АЖИЛЛАЖ БАЙНА</p> <p>Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын албан хаагч нар 24 цагийн бэлэн байдалтай Цагааннуурын авто замын шалган нэвтрүүлэх боомт, Өлгий-Ховд чиглэлийн авто замын пост, Нисэх буудал, Автоотээврийн төвд дэмжлэгт хяналт, тандалт хийж, мөн аймгийн Засаг даргын Тамгын газарт байрлаж буй төв штаб болон Мэргэжлийн хяналтын газарт шуурхай штаб, хариуцлагатай жижүүрээр ажиллаж, мэдээ мэдээллийн холбогдох газарт уламжилж байна.</p>
3	<p style="text-align: center;">НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА УХАМСАРЛАЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖҮҮД</p> <p>COVID-2019 халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Мэргэжлийн хяналтын газраас өгөгдсөн үүрэг чиглэлийн дагуу аймгийн Баян-Цамбагарав супермаркетууд, Алтыншах, Манка нарийн боовны цехүүд нийгмийн хариуцлагын хүрээнд орчин тойрныг цэвэрлэж, ариутгал, халдваргүйтгэлийг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж, биелэлтийг хангуулан ажилласан байна.</p>
4	<p>Нисэх буудалд хяналт, тандалт хийлээ</p> <p>Covid-19 халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах төлөвлөгөөний дагуу Мэргэжлийн хяналтын газрын эрүүл мэндийн чиглэлийн улсын байцаагч нар болон Шипагер өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нартай хамтран Өлгий-Улаанбаатар, Улаанбаатар-Өлгий чиглэлд зорчсон 149 зорчигчдын эрүүл мэндийн байдалд хяналт, тандалт хийлээ.</p> <p>Зорчигчдоос асуумж судалгаа авсан ба хяналт, тандалтаар сэжигтэй тохиолдол илрээгүй</p>
5	<p>2020 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн өглөө 06:00 цагаас оройн 17:00 цагийн байдлаар Монгол улсын Онцгой Комиссын 2020 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн “Зорчигч тээврийн хөдөлгөөнийг</p>

	<p>нээх, зарим хязгаарлалтын арга хэмжээ авах тухай” 03 тоот тогтоолын дагуу өнөөдөр 06:00 цагаас Хот хоорондын зорчигч тээвэр, судлын галт тэрэг болон орон нутгийн хуваарьт нислэг, хувийн тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг нээсэнтэй холбогдуулан өнөөдөр Өлгий-Ховд чиглэлийн хяналтын постоор өглөөний 06:00 цагаас оройн 17:00 цагийн хооронд орж гарах хөдөлгөөнд 150 гаруй тээврийн хэрэгсэл, 700 гаруй зорчигч зорчсон байна.</p> <p>Хяналтын постод аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Автотээврийн төвийн алба хаагч нар ажиллаж, халууныг хэмжиж, эрүүл мэндийн асуумж авч ажиллаж байна.</p>
6	<p>Хүүхдийн сургууль, цэцэрлэгүүд ариутгал халдваргүйтгэл хийж байна</p> <p>COVID-2019 халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Мэргэжлийн хяналтын газрын даргын мэдэгдэл, улсын байцаагчдын хамтарсан зөвлөмжийг сургууль, цэцэрлэгүүдэд хүргүүлсэний дагуу Цагааннуур тосгон, Өлгий сумын Зайд, Дарын, Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль, 14 дүгээр цэцэрлэг байрны гадна, дотор, бүх өрөө тасалгаануудын хог хаягдлыг цэвэрлэж, ариутгал халдваргүйтгэл хийж, биелэлтийг хангуулсан нь сайшаалтай байна.</p>
7	<p><b>“Мөнхийн хөршдөө сэтгэлийн дэмжлэг” аянд мэргэжлийн хяналтын байгууллага нэг өдрийн цалингаа хандивлав.</b></p> <p>“Мөнхийн хөршдөө сэтгэлийн дэмжлэг” аяны хүрээнд Бүгд Найрамдах Хятад Ард Улсад аймгийн Мэргэжлийн хяналтын газрын хамт олон 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр нэг өдрийн цалин буюу нийт 2024000 төгрөгний хандив өгч, дэмжлэг, тусламж үзүүллээ.</p>
8	<p><b>“КОД-9” сэдэвт дасгал сургуулилт зохион байгууллаа.</b></p> <p>Аймгийн Засаг даргын орлогч Ш.Хавылын баталсан удирдамжаар 2020 оны 3 дугаар сарын 02-ны өдөр Нисэх буудалд Эрүүл мэндийн газар, Зооноз өвчин судлалын төв, Нэгдсэн эмнэлэг, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Шипагер, Өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтарч цагийн байдал зарлаж “Код-9” сэдэвт бүрэн хэмжээний нийт 70 гаруй төлөөлөл оролцож, дасгал сургуулилт хийлээ.</p> <p>Сургуулилт Монгол улсын Шадар сайдын 2017 оны А/08 дугаар “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам”-ын дагуу мэргэжлийн байгууллагууд шуурхай мэдээлэл солилцож, баталсан удирдамжийн дагуу үүргээ гүйцэтгэж, салбар хоорондын уялдаа холбоог хангаж ажиллалаа.</p> <p>Дасгал сургуулилтын явц, гүйцэтгэл, үр дүн, алдаа, ололтын талаар дүнгийн хурал хийж, цаашид анхаарах асуудлыг зөвлөлдөв. Нийт 70 гаруй төлөөлөл оролцов</p>
9	<p><b>СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГҮҮДЭДИЙН АГУУЛАХАД ХАДГАЛАГДАЖ БАЙГАА ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙЖ БАЙНА.</b></p> <p>Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын холбогдох хяналтын улсын байцаагчид хорио цээр тогтоогдсон хугацаанд аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор бүх шатны сургууль, цэцэрлэгүүдэд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт болон хүнсний агуулахад хадгалагдаж байсан мах, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, хадгалалтын горим, хэрэглэж дуусах хугацаа, ариун цэвэр, ариутгал халдваргүйжүүлэлтийн байдалд хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.</p>